



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн
байгуулах баримт бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ын 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Трасс чэйн менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Трасс чэйн фонд” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Трасс чэйн менежмент ҮЦК” ХХК /Б.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.

1/ Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, мэргэжлийн ёс зүйтэй ажиллах;

2/ Үүсгэн байгуулсан “Трасс чэйн фонд” хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, сангийн нэгж эрхийн танилцуулгад нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд Хороонд тухай бүр мэдэгдэн холбогдох баримт бичгийг бүртгүүлэх;

3. Тогтоол батлагдсанаас хойш ажлын 15 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

